

МОНГОЛ ГЭРИЙН БҮТЭЦ, ҮГ, ХЭЛЛЭГИЙГ МЭДЭХ



D.Urantsetseg@must.edu.mn

МОНГОЛ ГЭРИЙН БҮТЭЦ

ТООНО


УНЬ



ХАНА

ХААЛГА

ЭСГИЙ БҮРЭЭСНИЙ БҮРДЭЛ



Монгол гэрийн бүтцэд орох хийц ба эдүүд угсардаг оньсон байдаг. Тэд бүгд нэг нэгнээсээ салдаг, барьж явахад хөнгөн, нүүж суухад маш тохиромжтой хийгддэг. Ямар ч орон сууцны босоо тэнхлэг дэхь зай багтаамж хананаас хамааралтай. Монгол гэрийн ханыг байшингийнх шиг бүхэл хавтгай хийвэл нүүдэл хийх ямар ч боломжгүй. Гэрийн хэмжээ том, жижиг байхаас хамаарч бүтцийн хэмжээнүүд өөрчлөгдөнө.

Монгол гэрийн бүтэц нь гэрийн хэлбэрийг бий болгогч гэрийн мод ба бүрж битүүлэх зөөлөн эд бүрээс гэсэн хоёр хэсэг болон ангилагдана.

Гэр бол геометрийн огтлолцол бүхий конус хэлбэртэй. Гэрийн бүтэц дэх хэсгүүд хоорондоо угсралтын нарийн дүрэмтэй байна. Тухайн гэрийн хэмжээнээс хамаарч хэсгүүдийг хийх тогтсон хэмжээ өгөгдсөн байдаг. Энэ хэмжээгээр хийгдсэн хэсгүүдийг хооронд нь зөв угсарч гэрийг барьж босгоно.



ГЭРИЙН МОДНЫ БҮРДЭЛ

ХАНА

ТООНО

УНЬ




ХААЛГА

БАГАНА

ШАЛ

ГЭРИЙН БҮРЭЭСНИЙ БҮРДЭЛ



Гэрийн том жижиг, дугуй хэлбэртэй байхыг гэрийн хана гүйцэтгэнэ. Гэрийн хэмжээ янз бүр байна. Монгол гэр ханын тоо (4, 5, 6, 8, 10, 12) ширхгээс хамаарч нэрлэгдэнэ. Монгол гэрт хатавчны хана ба хатавчны биш гэж байна. Нэг хана хоёр захаараа нөгөө хануудтай холбогддог ханыг хатавчны биш хана гэнэ.

ТЭРЭМ



ХААЛГА


Эртнээс эсгий гэрт унжуулсан ширмэл эсгий хаалтыг дээш сөхөж орж гардаг байсан. Орчин үед 18,19-р зуунаас модон хаалга хэрэглэх болжээ. Гэрийн модон хаалга ханатай адил гэрийн дээд хэсгээс ирэх ачааллыг дааж байдаг. Хаалганы хийцийн хувьд дан ба давхар ястай хийнэ. Давхар хийгддэг учир бол хүйтний улиралд хүйтнээс идэвхтэй тусгаарлах зориулалттай.



Монгол гэрт гэрэл гэгээ оруулах, утаа уурыг гаргах, унь тогтоох голдоо хөндлөн гулд чагт тэмдэгтэй дугуй цагираг хүрээг тооно гэнэ. Тооныг дөрвөд баядууд “хараач”, өөлд торгууд, урианхай, захчингууд “гараац” гэдэг. “Хараач” гэдэг нь од эрхэс, гэгээ гэрэл, тэнгэрийн байдал зэргийг нүдээр үзэх гэсэн санаанаас үүдэлтэй, “гараац” гэдэг нь гэр доторхи задгай галын утаа, цай хоолны уур униар гэр дотроос гадагшлах, гарах гэсэн утгаас үүдэлтэй ажээ. Гэрийн тооныг улаан, улбар шар өнгөөр голчлон буддаг нь нарны бэлгэдэлтэй холбоотой юм. Мөн хүний бие эрхтэнээр төлөөлүүлэн хэлбэл толгой, тэргүүн болно. Тийм учраас тоонон дээгүүр алхах, гишгэхийг цээрлэнэ.

САРХИНАГАН ТООНО

Уньтайгаа
хэлхээтэй,
голчоороо хоёр
салдаг



ЦАМХРАА ТООНО

Энгийн хийц бүтэцтэй учир
хөнгөн, бөх бат байдаг



ХҮРДТЭЙ ТООНО

Голыг тойруулан модон
цагирагаар бэхэлсэн
тэр хэсгийг хүрд буюу
хорол гэж нэрлэдэг



УЯНГЫН ТОЙРОГ

Үр нь мөлхөж босго
даван
Үүлгүй тэнгэрээр
татуулж босно
Гэрийнхээ доод
бүслүүрээс дэмнэж
Гишгэж анх үзнэ, үр нь

8 ТООНЫ БИЛЭГДЭЛ

Наймын тоогоор ертөнцийн дунд тивийн аж амьдралыг бэлгэддэг. Гэгээн зүсмийн найман морийг тахил хүндэтгэлийн утгаар “жаргалын найман морь” хэмээнэ. “Шашны найман тахил”-аар жаргал цэнгэл, өв тэгш амьдрал ахуй, бүтэн эд эрхтэн, бүрэн хүч тэнхлийг бэлгэддэг. Ертөнцийн орон зайн төсөөлөл буюу найман зовхисыг илэрхийлнэ. Тийм учраас наймын тоо нь баяр жаргал, элбэг дэлбэг, урт удаан нас, үүрд мөнхийн бэлгэдэл болно.

Сурах бичиг-139 хууда

 **ДАСГАЛ-5**

